

“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 26-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурал: 2024 оны 04-р сарын 26-ны өдрийн 11.00 цагт Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот “Асби” ХК-ийн хурлын танхимд боллоо.

Хурлын ирц: Хуралд нийт 59,670 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч оролцсоноос танхимд 4 хувьцаа эзэмшигч ирсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурал хүчин төгөлдөр болсон тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай 02 тоот тогтоолоор томилогдсон Тооллогын комиссын 2024 оны 04 сарын 26-ны өдрийн 01 дугаартай тогтоолыг Тооллогын комиссын дарга М.Сугармаа уншиж танилцууллаа.

Тогтоолд: “Асби” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчээс 4 хувьцаа эзэмшигч ирж хуралд оролцсон нь 59,670 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 94.03% болж Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээж, хурлын дарга Д.Лхагвасүрэн үг хэлэв.

-Сайн байцгаана уу. Цаг заваа зориулан хуралдаа ирсэн та нарт баярлалаа. Ингээд хэлэлцэх асуудлуудаа хэлэлцээд шийдвэрүүдээ гаргаад явъя.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хараат бус аудиторын дүгнэлтийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
3. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв батлах

Хэлэлцэх асуудал 1. -Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт болон үйл ажиллагааны тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, эсэх

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал 2. - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Гишүүдийн танилцуулгыг танилцуулж хүргүүлсэн байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Д.Лхагвасүрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал
2. Л.Сүмбанд 59670 ширхэг буюу 100%-ийн санал

3. Ч.Дашцэрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал
4. С.Буман-Эрдэнэ 59670 ширхэг буюу 100%-ийн санал
5. Б.Доржсүрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал
6. С.Бат-Эрдэнэ 59670 ширхэг буюу 100%-ийн санал

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Э.Буянтогтох 59670 ширхэг буюу 100%-ийн санал
2. Ц.Хадаа 59670 ширхэг буюу 100%-ийн санал
3. Л.Нямдаваа 59670 ширхэг буюу 100%-ийн санал тус тус 100%-ийн санал өгсөн байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх заалт, СЗХ-ны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй болж байна.

Хэлэлцэх асуудал 3. - Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв батлах

Энэ жилийн ТУЗ-ын төсвийг өнгөрсөн жилийн төсөвтэй ижил байхаар 900,000 төгрөгөөр батлуулахаар оруулсан байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хурлын тогтоол баталж, Хурлын дарга Д.Лхагвасүрэн дээрх дүгнэлтийг үндэслэн хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар ХЭХ-ын тогтоол тус бүрийг уншиж танилцуулан батлав.

Цаашид компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх тал дээр дорвитой арга хэмжээ авахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгов.

Ийнхүү энэ удаагийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН
А.НАМУУНТУУЛ
М.СУГАРМАА

Хурлын дарга Д.Лхагвасүрэн: Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт хариулт байхгүй тул санал хураалтаа явуулж, хурлын шийдвэрээ гаргая.

Тооллогын комиссын дарга М.Сугармаа: Санал хураалтын хугацаа дууссан байна. Санал хураалтын дүнг танилцуулъя. 2024 оны 04 сарын 26-ны өдрийн Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг уншиж танилцууллаа.

Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалт 2024 оны 04 сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Асби” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, зөвшөөрсөн 4 буюу санал хураалтын дүнгээр 100% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг 100% көвшөөрсөн тул хүчинтэйд тооцсугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох кумулятив аргаар хураасан санал хураалт нь Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.3-т заасан шаардлагыг хангаж байгаа тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.

Тооллогын комиссын дарга М.Сугармаа гэжээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн нь:

Нэгдүгээр асуудал: “Асби” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2024 оны 04 сарын 26-ны өдрийн 01 тоот “Компанийн тухай хуулийн 62-р зүйдийн 62.1.9 дэх заалт, 2024 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Асби” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудал: “Асби” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2024 оны 04 сарын 26-ны өдрийн 02 тоот “Компанийн тухай хуулийн 62-р зүйдийн 62.1.7 дэх заалт, 2024 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Асби” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр

1. Д.Лхагвасүрэн
2. Л.Сүмбанд
3. Ч.Дашцэрэн
4. С.Буман-Эрдэнэ
5. Б.Доржсүрэн
6. С.Бат-Эрдэнэ

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр

1. Э.Буянтогтох
2. Л.Нямдаваа
3. Ц.Хадаа нарыг тус тус сонгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжийг баримтлан, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг үүрэг болгосугай.

Гуравдугаар асуудал: “Асби” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2024 оны 04 сарын 26-ны өдрийн 03 тоот “Компанийн тухай хуулийн 62-р зүйдийн 62.1.13 дэх заалт, 2024 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын 2024 оны төсвийг 900,000 /есөн зуун мянган/ төгрөгөөр тогтоосугай.

2. Төсвийн зардалд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Нашуунтуул



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцаа Эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал
хүчин төгөлдөр болсныг батлах тухай

Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “АСБИ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчдээс 4 хувьцаа эзэмшигч ирж хуралд оролцсон нь нийт саналын эрхтэй хувьцааны 94.03% (59,670 ширхэг) болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН

ДУГА



M. Sugarmaa

М.СУГАРМАА